

Дараах мэдээллүүдийг Япон хэлнээс орчуулсан болно.

4

2021 оны 5 сарын 20-ны өдрөөс

Гамшгаас хоргодох зааврын дагуу заавал хоргодох

Гамшгаас хоргодох зөвлөмж зарлахаа больсон

Сэрэмжлүүлгийн түвшин	Гамшгаас хоргодох шинэ мэдээ	Гамшгаас хоргодох хуучин мэдээ
5	Байгалийн гамшиг үүссэн үүсэх аюул нөхцөлзүйн Нэн яаралтай ※1 аюулгүй байдлаа хангах	Байгалийн гамшиг үүссэнталаарх мэдээ (Үүссэн нь тодорхой болмогц зарлана) Гамшгаас хоргодох заавар (яаралтай) Гамшгаас хоргодох зөвлөмж Гамшгаас хоргодоход бэлдэх өндөр настнуудыг нүүлгэн шилжүүлж эхлэх Аадар бороо, үер ус, далайн түрлэгийн анхааруулга (Японы Цаг Уурын Агентлаг) Урьдчилан сэргийлэх анхааруулга (Японы Цаг Уурын Агентлаг)
~<Сэрэмжлүүлгийн түвшин 4-с өмнө заавал хоргодох>		
4	Гамшгийн эрсдэл өндөр Гамшгаас хоргодох заавар ※2	
3	Гамшгийн эрсдэлтэй Өндөр настан зэрэг ※3 хүмүүс аюулгүй газарт хоргодох	
2	Цаг агаарын байдал хүндэрсэн Аадар бороо, үер ус, далайн түрлэгийн анхааруулга (Японы Цаг Уурын Агентлаг)	
1	Цаашид цаг агаарын байдал хүндэрэх эрсдэлтэй Урьдчилан сэргийлэх анхааруулга (Японы Цаг Уурын Агентлаг)	

Жич 1: Орон нутаг гамшгийн байдлыг бүрэн тогтоох боломжгүй тул сэрэмжлүүлгийн түвшин 5-ыг тухай бүрд зарлах албагүй.

Жич 2: Гамшгаас хоргодох зааврыг өмнө зарладаг байсан гамшгаас хоргодох зөвлөмжтэй ижил нөхцөлд зарлана.

Жич 3: Сэрэмжлүүлгийн түвшин 3 нь өндөр настнаас бусад иргэд ч мөн шаардлагатай тохиолдолд нөхцөл байдалд тохируулан арга хэмжээ авч, гамшгаас хоргодох бэлтгэлээ ханган, аюултай гэж үзвэл сайн дураараа гамшгаас хоргодох үе юм.

Сэрэмжлүүлгийн түвшин 5 нь аюулгүй газарт хоргодох боломжгүй, амь насанд аюул учрахуйц байдлыг илтгэнэ.
Сэрэмжлүүлгийн түвшин 5, нэн яаралтай аюулгүй байдлаа хангахыг зарлах хүртэл хүлээж огтхон ч болохгүй!

Гамшгаас хоргодох зөвлөмж зарлахаа больсон.
Харин одоо сэрэмжлүүлгийн түвшин 4, гамшгаас хоргодох зааврын дагуу бүгд аюултай газраас хоргодно уу.

Хоргодоход хугацаа шаардагдах өндөр настнууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд сэрэмжлүүлгийн түвшин 3, өндөр настнууд хоргодох зааврын дагуу аюултай газраас хоргодно уу.



"Гамшгаас хоргодох" -ынтулд юу хийх ёстой вэ?

Гамшгаас хоргодох гэдэг нь бага дунд сургууль, олон нийтийн төвд очих төдийгээр хязгаарлагдахгүй. "Гамшгаас хоргодох" гэдэг нь аюулаас зайлсхийхийг хэлнэ. Дараах 4 төрөлд хуваагдана.



Орон нутгаас заасан хоргодох байранд очиж хоргодох

Биедээ авч явах зүйлс:
 Маск
 Ариутгагч шингэн
 Халууны шил
 Шахай г.м

Бага, дунд сургууль
 Олон нийтийн төв

Аюулгүй газарт буй хамаатан, найз нөхдийндөө очиж хоргодох

Гамшгийн үед очиж хоргодох талаар урьдчилан тохирох.
 Жич: Гамшгийн зураглал дээрээс аюулгүй эсэхээ шалгах.

Хамаатан, найз нөхдийн гэр

Гамшгийн үед юу хийхээ урьдчилан шийднэ үү.

Аюулгүй газарт буй зочид буудал, дэн буудалд очиж хоргодох

Буудлын төлбөр төлөх шаардлагатай.
 Урьдчилан захиалга өгөх юм уу лавлах.
 Жич: Гамшгийн зураглал дээрээс аюулгүй эсэхээ шалгах.

Зочид буудал
 Дэн буудал

Байшин, барилга дотор аюулгүй байдлаа хангах

Гамшгийн зураглал дээрээс дараах "3 нөхцөл"-ийг хангасан эсэхээ шалгах шаардлагатай.

Энд аюулгүй!

Усанд автах магадлалтай хамгийн дээд цэг

Жич: Хөрсний гулгалт үүсэх аюултай бүс нутагт бол заавал аюулгүй газарт очиж хоргодох ёстой.

"Дараах 3 нөхцөл"-ийг хангасан тохиолдолд усанд автах аюултай байсан ч гэртээ байж аюулгүй байдлаа хангаж болно

1 Байр сууц нурах эрсдэл бүхий үерийн аюултай бүсэд амьдардаггүй (Амьдардаг бол...)



Усны түргэн урсгалд модон байр сууц нурах эрсдэлтэй

Газрын гадарга эвдэрч байр сууц бүхэлдээ нурах эрсдэлтэй

2 Байр сууц тань усанд автах өндрөөс дээш байрладаг



3 Ус татартал тэвчиж болохуйц төдийгүй ус, хоол хүнсний хангалттай нөөцтэй (Хангалтгүй тохиолдолд...)

Ус, хоол хүнс, эм тарианы хангамж дутагдахын зэрэгцээ цахилгаан, газ, цэвэр бохир ус, жорлон ашиглах боломжгүй болох эрсдэлтэй



Жич: 1 Байр сууц нурах эрсдэл бүхий үерийн аюултай бүс, 2 ус татрах хүртэлх хугацаа (үерийн үргэлжлэх хугацаа)-г гамшгийн зураглалд тэмдэглээгүй байх магадлалтай тул орон нутгийнхаа засаг захиргаанаас лавлана уу.

Ширүүн бороотой үед машинтай байсан ч гадагш гарах нь аюултай. Машинаа хонохоос өөр аргагүй болсон тохиолдолд үерт автах аас сэргийлж, ойр орчноо сайтар нягталж шалгана уу.